# МОНГОЛ УЛСЫН
# ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
# САЙДЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 24 өдөр  Дугаар А/28  Улаанбаатар хот

**Жагсаалт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг нэгдүгээр, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хоёрдугаар, Хил хамгаалах байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг гуравдугаар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг дөрөвдүгээр, Улсын бүртгэлийн байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тавдугаар, Архивын байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг зургадугаар, Гадаадын иргэн, харьяатын байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг долдугаар, Дотоод хэргийн их сургуулийн албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг наймдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/70, 2019 оны А/195, 2020 оны А/143, А/171 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Б.Баасандорж/, Цагдаагийн ерөнхий газрын дарга /Ж.Болд/, Хил хамгаалах ерөнхий газрын дарга /Х.Лхагвасүрэн/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /Д.Загджав/, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга /Д.Дэлгэрсайхан/, Архивын ерөнхий газрын дарга /С.Энхбаатар/, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга /Н.Ууганбаяр/, Дотоод хэргийн их сургуулийн захирал /П.Батбаатар/ нарт үүрэг болгосугай.

Х.НЯМБААТАР

1119287523 ШТТ6740 9131817

*Doc\tushaal Said. 2021*

151600147

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021
оны 02 дугаар сарын 24-ны өдрийн A/28
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1119287523 ШТТ6740 9131817

# ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээлэл |
|---|---|
| 1. | Албаны нууцад хамаарах асуудлаар баталсан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаал, холбогдох мэдээ, баримт бичиг |
| 2. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг |
| 3. | Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө |
| 4. | Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, бусад нууц тээгч |
| 5. | Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээлэл |
| 6. | Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээ, акт, баримт бичиг |
| 7. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл |
| 8. | Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүртгэлийн дэвтэр |
| 9. | Нууц тээгчийг устгасан, олшруулсан баримт бичиг |

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/24 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

# ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээлэл |
|---|---|
| 1. | Шүүх, цагдаагийн төв байр, гэрч хохирогчийг хамгаалах, албадан саатуулах, эрүүлжүүлэх, албад нэгжийн байрны аюулгүй байдлын хамгаалалт, дохиоллын болон хяналтын хүч хэрэгсэлтэй холбоотой мэдээлэл |
| 2. | Гэрч, хохирогчийн аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээний хяналтын хэрэг, бүртгэлүүд, арга хэмжээний талаарх мэдээлэл агуулсан танилцуулга, илтгэх хуудас, үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоот хуваарь, хамгаалуулагчийн хөдөлгөөний чиглэл |
| 3. | Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах, яллагдагч, шүүгдэгч, ялтныг цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хуяглан хүргэх үеийн хамгаалалтын төлөвлөгөө, удирдамж, тактик, аргачлал холбогдох баримт бичиг |
| 4. | Байгууллагын шуурхай удирдлагын суурин, хөдөлгөөнт командын байр, холбооны зангилаа, радио, техник хэрэгслийн зохион байгуулалт, байршил, үелзлийн хуваарилалтын тухай мэдээлэл агуулсан нууц тээгч |
| 5. | Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэглэлд шилжүүлэн ажиллуулах төлөвлөгөө, нөхцөл байдал хүндэрсэн үед цагдаагийн байгууллагуудын харилцан ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөө, хэрэглэх дохио |
| 6. | Байгууллагын гамшгаас хамгаалах ажлын төлөвлөгөөний хавсралт |
| 7. | Гэмт хэрэг, терроризмоос урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх чиглэлээр олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага-Интерполын Ерөнхий нарийн бичгийн даргын газар болон тус олон улсын байгууллагын гишүүн орнуудын Үндэсний төв товчоодоос “INTERPOL Restricted” /Интерпол хязгаарлагдсан буюу эрх бүхий ажилтан танилцах/, “INTERPOL Confidental” /Интерпол нууц/ гэсэн нууцын зэрэглэл тэмдэглэгээтэй ирсэн хүсэлт, материал, тэдгээрийн хариу |
| 8. | Теле хяналтын систем, сүлжээний холболтын зураглал, нууцлал, хамгаалалтын технологи |
| 9. | Цагдаагийн ерөнхий газрын сүлжээний төхөөрөмжүүдийн холболтын зураглал |
| 10. | Төвийн сүлжээнд холбогдсон байгууллагуудын сүлжээний төхөөрөмжүүдийн IP хаягын жагсаалт |
| 11. | Албаны галт зэвсэг, тусгай техник, тусгай хэрэгсэл /гав, бороохой/, галт хэрэглэл /сум дагалдах хэрэгсэл/, галт зэвсгийн адилтгах хэрэгслийн хангалт, захиалга, нөөцийн талаарх мэдээлэл, бүртгэл, судалгаа, тооллогын болон бусад баримт бичгүүд |
| 12. | Иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, галт хэрэглэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийн нэгтгэсэн бүртгэл, тооллогын мэдээлэл агуулсан нууц тээгч |
| 13. | Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулах нэгдсэн болон хэсэгчилсэн ажиллагаа явуулах удирдамж, төлөвлөгөө, тактик аргачлал, үр дүнг тооцсон баримт бичиг |
| 14. | Гэмт хэрэг, зөрчлийн эх сурвалжийн талаар үнэн бодитой мэдээ, мэдээлэл өгсөн иргэний холбогдох мэдээлэл |
| 15. | Цагдаагийн албанд ашиглаж байгаа үүрэн холбооны сүлжээний орчинд мэдээлэл дамжуулах програм хангамж, дагалдах тоног төхөөрөмж |
| 16. | Цагдаагийн албанд ашиглаж байгаа радио долгионыг ашиглан явуулж байгаа нэр, ярианд ашиглах шифр, дуудлага, тэдгээрийн түлхүүр, тайлбар технологи |

| | |
|---|---|
| 17. | Дотоод аюулгүй байдлын чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, танилцуулга, илтгэх хуудас |
| 18. | Албаны нууцтай холбоотой хяналт шалгалтын болон албаны шалгалтын материалууд |
| 19. | Алба хаагчдын хувийн хэрэг, түүнтэй холбоотой мэдээллүүд |
| 20. | Алба хаагчдын албаны нууцад хамаарах сургалт, үүрэг даалгаврын дэвтэр |
| 21. | Албаны нууцад хамаарах мэдээлэл ашиглан бэлтгэсэн ном, сэтгүүл, гарын авлага |
| 22. | Байгууллагын мэдээллийн сангийн төв сервер, нөөцлөлт, хадгалалт, хамгаалалтын өрөөний байршил, цэг, эрсдэлийн үед систем, санг нөхөн сэргээх төлөвлөгөө, компьютерийн нууц код бүртгэл |
| 23. | Өргөдөл, гомдлын сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 24. | Захиргааны зөрчлийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 25. | Гэмт хэргийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 26. | Захиргааны тоо бүртгэлийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 27. | Судалгаа, хяналтын сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 28. | Тайлан судалгааны сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 29. | Эрэн сурвалжлалтын сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 30. | Хүний нөөцийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 31. | Цагдаагийн байгууллагын цахим үйлчилгээний сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 32. | Галт зэвсгийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 33. | Гэрээт харуул, хамгаалалтын сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 34. | Тэсэрч, дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих бүртгэлийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 35. | Мэдээ, мэдээллийн 307 систем, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 36. | Өргөдөл, гомдлын цахим зураглал болон гэмт хэргийн цахим зураглалын сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |

| | |
|---|---|
| 37. | Эргүүл удирдлагын сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 38. | Хамгаалалтын систем, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 39. | Мэдээлэл танилцуулгын сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 40. | Дуудлагын мэдээлэл бүртгэлийн сан /ECS/, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 41. | Хууль бус аргаар ашигт малтмал олборлогч иргэдийн бүртгэлийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 42. | Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах сан, түүний сүлжээний бүтэц зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 43. | Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 44. | Хүч хэрэгслийн бүртгэлийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 45. | Ял шийтгэлийн лавлагааны сан, түүний сүлжээний бүтэц зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 46. | Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын эрх бүхий алба хаагчдад олгосон цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийн код |
| 47. | Дотоод сүлжээ, ашиглаж байгаа програм хангамжийн мэдээлэл, түүнд засвар үйлчилгээ хийсэн болон өргөтгөсөн тухай бүртгэл |
| 48. | Төвийн сүлжээнд холбогдсон байгууллагуудын сүлжээний төхөөрөмжүүдийн IP хаягийн жагсаалт |
| 49. | Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө |
| 50. | Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч |
| 51. | Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээлэл |
| 52. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг |
| 53. | Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж |
| 54. | Байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай мэдээлэл |
| 55. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл |
| 56. | Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр |

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/28 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

# ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээлэл |
|---|---|
| 1. | Улсын хил хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төлөвлөгөө, биелэлт |
| 2. | Хилийн /отряд/ анги, тусгай салбар, хилийн болон шалган нэвтрүүлэх застав, харуулын хариуцсан хэсэг, хил хамгаалалт, албаны нууц мэдээлэл агуулсан танилцуулга |
| 3. | Улсын хилийн шугамын явалт, хариуцсан хэсгийн урт, хилийн тэмдэг, уулзвар, гүний хязгаарлах шугамын талаарх мэдээлэл |
| 4. | Улсын хил хамгаалалтын үр дүнгийн мэдээ, нэгдсэн статистик үзүүлэлт, дүн шинжилгээ |
| 5. | Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн болон барилга, байгууламжийн нэгдсэн судалгаа, бүтэц, байршил, тоо, зураг, төсөв |
| 6. | Зэвсэг, байлдааны техник, хүн хүчний тоог тодорхойлсноос бусад хангалтын төрөл, тоо хэмжээ, хуваарь, нөөцийн тухай мэдээлэл |
| 7. | Улсын хил хамгаалалтын зориулалтаар газар зүйн мэдээллийн системд боловсруулсан орон зайн мэдээлэл |
| 8. | Хилийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, хил хамгаалалтын хүч хэрэгслийн мэдээ |
| 9. | Хил хамгаалах албаны бэлэн байдлын төлөвлөгөө, дохиогоор ажиллах, зарлан мэдээлэх, цугларах журам, томилгоо |
| 10. | Хилийн болон шалган нэвтрүүлэх албаны хоногийн төлөвлөгөө /хөтөлж эхэлмэгц/ |
| 11. | Хилийн тэмдгийн дэвтэр /хөтөлж эхэлмэгц/, |
| 12. | Хил залгаа улстай болон өөрийн хилийн отряд, заставтай зохион байгуулсан хамтарсан хил хамгаалалт, тусгай ажиллагаа болон дадлага, сургуулийн ажиллагааны бодлого, тайлбар бичиглэл |
| 13. | Албаны нууцад хамаарах мэдээлэл агуулсан цэргийн байр зүйн зураг, зургийн сан |
| 14. | Хилийн заставын дарга болон сургалт эрхэлсэн орлогчийн ажил хүлээлцсэн акт |
| 15. | Улсын хил нэвтэрсэн тухай тэмдэглэл хийх дардас /штамп/-ны ул |
| 16. | Халагдах хугацаат цэргийн алба хаагчдын аймаг орон нутаг, дүүргийн цэргийн штабт өгөх нэрсийн жагсаалт |
| 17. | Хил хамгаалах байгууллагын албаны програм хангамж, түүний эх код, төрийн нууцад хамаарахаас бусад мэдээллийн сан болон сервер, сүлжээний төхөөрөмжид нэвтрэх нэр, нууц үг, бүдүүвч зураг, ашиглалтын заавар |
| 18. | Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэл |
| 19. | Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн акт, бүртгэл |
| 20. | Төрийн болон албаны нууц баримт бичиг бүртгэсэн бүртгэлийн дэвтрүүд |
| 21. | Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтнуудад албаны шалгалт хийсэн материал |
| 22. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг |

| | |
|---|---|
| 23. | Албаны нууцад хамаарах асуудлаар байгуулсан хамтран ажиллах гэрээ, санамж бичиг |
| 24. | Архивд хадгалагдаж байгаа төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичгийн данс, бүртгэл, хөмрөгийн хэрэг |
| 25. | Зэвсэг байлдааны техник, хүн хүчний тоог тодорхойлсноос бусад хилийн отряд /анги/, тусгай салбарын төсөв, санхүүжилтийн хуваарь, гүйцэтгэлийн тухай мэдээлэл |
| 26. | Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн систем, арга ажиллагаа, бүртгэл судалгаа |
| 27. | Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч |
| 28. | Төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай мэдээлэл |
| 29. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл |
| 30. | Зэвсэг, галт хэрэглэлийн тоо ширхэг, байлдааны иж агуулсан мэдээлэл, баримт бичиг, бүртгэлийн дэвтрүүд /хөтөлж эхэлмэгц/ |
| 31. | Хилийн харуулын албаны дэвтэр /хөтөлж эхэлмэгц/ |
| 32. | Хилийн зөрчлийн материал, бүртгэл, судалгаа |
| 33. | Хилийн төлөөлөгч, орлогч, туслагчийн уулзалтын төлөвлөгөө, холбогдох материал |
| 34. | Хилийн эрэл, хилийн тусгай ажиллагааны төлөвлөлт, тооцоо, тайлан |
| 35. | Хил хамгаалалтын хувилбарууд |
| 36. | Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах тухай удирдамж, тушаал, захирамжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон баримт бичиг |
| 37. | Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа болон хилийн нөхцөл байдлын танилцуулга мэдээ |
| 38. | Радио холбооны техник хэрэгслийн программын тохиргоо |

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/28 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт

1119287523 ШТ15740 9131817

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээлэл |
|---|---|
| 1. | Албаны нууцад хамаарах асуудлаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын даргын баталсан тушаал, холбогдох мэдээ, баримт бичиг |
| 2. | Хуяглан хүргэх ажлын заавар |
| 3. | Оргосон хоригдогчийг эрэн сурвалжлах, баривчлах ажиллагааны заавар |
| 4. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын галт зэвсгийн бүртгэл |
| 5. | Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч |
| 6. | Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний зарим мэдээлэл |
| 7. | Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө |
| 8. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг |
| 9. | Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийн хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж |
| 10. | Байгууллага, харьяа байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай тэмдэглэл |
| 11. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл |
| 12. | Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр |

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/28 дугаар тушаалын тавдугаар хавсралт

1119287523 ШТТ6740 9131817

# УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээлэл |
|---|---|
| 1. | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан /улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн/ |
| 2. | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн систем, сүлжээний аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн мэдээлэл, холбогдох баримт бичиг |
| 3. | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн хаалттай мэдээллийг ашиглахтай холбоотой байгуулсан гэрээ, хэлцэл |
| 4. | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай холбоотой гүйцэтгэгч сонгон шалгаруулсан тендерийн баримт бичгүүд |
| 5. | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай холбоотой хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн холбогдох баримт материал |
| 6. | Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архив |
| 7. | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нэвтрэх нууц үг |
| 8. | Иргэний биеийн давхцахгүй өгөгдөл /гар хурууны хээ/ |
| 9. | Үндэсний гадаад паспортын бэлдэц нийлүүлэх, бичилт хийлгэхтэй холбоотой гэрээ, хэлцэл |
| 10. | Иргэний үнэмлэхийн бэлдэц нийлүүлэлт, хэвлэх тоног төхөөрөмжийн гэрээ, хэлцэл |
| 11. | Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт хэвлэх үйлдвэрийн холбогдох баримт бичиг, схем, хэвлэх тоног төхөөрөмж |
| 12. | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмын дагуу хүргүүлсэн танилцуулах тойм мэдээ |
| 13. | Үндэсний гадаад паспорт, иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний загвар, тодорхойлолт, нууцлалыг баталсан тушаал, шийдвэр |
| 14. | Албаны нууцад хамаарах асуудлаар эрх бүхий албан тушаалтны гаргасан тушаал, шийдвэр |
| 15. | Сонгогчдын нэрийн жагсаалт /улс, аймаг, сум, дүүргийн хэмжээнд/ |
| 16. | Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө |
| 17. | Албаны нууцад хамаарах асуудлыг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч |
| 18. | Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээлэл |
| 19. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг |
| 20. | Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж |
| 21. | Байгууллага, харьяа байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай мэдээлэл |
| 22. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх тайлан, мэдээлэл |
| 23. | Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүртгэлийн дэвтэр |

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/28 дугаар тушаалын зургадугаар хавсралт

1119287523 ШТТ6740 9131817

# АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээлэл |
|---|---|
| 1. | Архивын баримтын Улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сан, түүний сүлжээний бүтэц, зохион байгуулалт болон програм хангамжийн эх код, нэвтрэх нууц түлхүүр үг, аюулгүй байдлыг хангах шийдэл, тохиргоо |
| 2. | Архивын ерөнхий газрын барилгын болон техникийн бүтцийн зураг |
| 3. | Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч |
| 4. | Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээлэл |
| 5. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан бичиг |
| 6. | Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө |
| 7. | Төрийн болон албаны нууцад хамаарах баримт бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж |
| 8. | Байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай мэдээлэл |
| 9. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл |
| 10. | Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр |

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/28 дугаар тушаалын долдугаар хавсралт

# ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээлэл |
|---|---|
| 1. | Гадаадын иргэн, харьяатын газарт ашиглагдаж байгаа бүртгэлийн систем дэх гадаадын иргэний бүртгэл, хяналт, виз, зөвшөөрөл, оршин суух, Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, сэргээн тогтоохтой холбоотой мэдээллийн болон гадаадын иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн сан, эдгээрийн мэдээллийн сүлжээ, програм хангамж, түүний бүтэц, системийн аюулгүй байдал, үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой баримт бичиг |
| 2. | Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон, цагаачаар оршин суугаа гадаадын иргэнтэй холбогдох баримт бичиг |
| 3. | Боловсруулалтын шатанд байгаа шийдвэрийн төсөл |
| 4. | Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, бусад нууц тээгч |
| 5. | Хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан хувь хүний мэдээлэл |
| 6. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг |
| 7. | Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээ, акт, баримт бичиг |
| 8. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл |
| 9. | Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүртгэлийн дэвтэр |
| 10. | Нууц тээгчийг устгасан, олшруулсан баримт бичиг |

---oOo---

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн А/28 дугаар тушаалын наймдугаар хавсралт

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН АЛБАНЫ НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт |
|---|---|
| 1. | Хүний нөөцийн мэдээллийн сангийн мэдээлэл, програм хангамж |
| 2. | Албаны нууцад хамаарах асуудлаар төслөөр боловсруулж байгаа баримт бичиг, эрх зүйн акт, тушаал, шийдвэр |
| 3. | Албаны нууцад хамаарах мэдээлэл ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан, илтгэл, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, иж бүрдэл, лекц, хичээлийн тэмдэглэл, дадлагын тайлан |
| 4. | Албаны нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хурлын тэмдэглэл, шийдвэр, нууц тээгч |
| 5. | Албаны нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг |
| 6. | Төрийн болон албаны нууцад хамаарах албан бичиг, нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн нотломж |
| 7. | Байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хяналт шалгалт, үзлэг тооллого хийсэн тухай тэмдэглэл |
| 8. | Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын талаарх мэдээлэл |
| 9. | Төрийн болон албаны нууц баримт бичгийн бүх төрлийн бүртгэлийн дэвтэр |
| 10. | Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө |

---oOo---